

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 23 оны 11 сарын 30 өдөр

№ R-2023-76

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд, гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") болон Аудитын хороо ("АХ") нь 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн тус тусын хурлаараа хэлэлцээд, Банкны эрх бүхий албан тушаалтантай хийх, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 417,300,000 (дөрвөн зуун арван долоон сая гурван зуун мянга) төгрөгийн үнийн дүнтэй зээл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-д зөвшөөрөл олгох зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь Ажилтны зээлийн ерөнхий журамд нийцсэн болохыг ЭУХ болон АХ тус тус тодорхойлсныг; мөн
3. ТУЗ нь ЭУХ болон АХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгохыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

## ТОГТООХ нь:

1. Тогтоолын хавсралтад заасан Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрч баталсугай.
2. Хэлцлийн нөхцөлд аливаа материаллаг өөрчлөлт ороход ТУЗ-д дахин танилцуулж зөвшөөрөл авахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БОГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ